



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

АВТОТЭЭВРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ ТӨҮГ-ЫН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН
ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Аудитын код: СНАГ-2024/86/НА-СТА-ТӨА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал,
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Б.Долгорсүрэн
Утас: 261885 Цахим хаяг: dolgorsurenb@audit.gov.mn
Ахлах аудитор: Ж.Бүжинханд
Утас: 261628 Цахим хаяг: bujinhandj@audit.gov.mn
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Гэрэлтэх бүртгэл Аудит ХХК
Захирал А.Сарангэрэл Утас: 99884842
Цахим хаяг: Gereltekhburtgelaudit3@gmail.com

Улаанбаатар хот
2024 он

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	2
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан	3
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	5
2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	6
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	8
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	8
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	8
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	9
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт ..	9
4. АУДИТЫН ТАЙЛАН	13
4.1 Ерөнхий зүйл	13
4.2 Материаллаг байдал	13
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .	14
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	14
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
4.5.1 Завсрын аудитын талаар.....	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	17
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	17

Товчилсон үгийн жагсаалт

ААНОАТ	Аж ахуй нэгжийн орлогын албан татвар
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
ЗТХС	Зам тээвэр, хөгжлийн сайд
МИАТ	Монголын иргэний агаарын тээвэр
МУЗГ	Монгол Улсын Засгийн Газар
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
УТҮГ	Улсын төсөвт үйлдвэрийн газар



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2024.03.25 № 07/832

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Автотээврийн үндэсний төв ТӨҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Автотээврийн үндэсний төв ТӨҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан.

Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Зам тээврийн хөгжлийн сайдын 2023 оны А/140 дугаар тушаалаар “Автотээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх улсын дугаар олгох журам”-д нэмэлт өөрчлөлт орж, тээврийн хэрэгслийн бүртгэлийн дугаарыг хадгалах үйлчилгээг шинээр нэвтрүүлсэн байна.

Тээврийн цагдаагийн албанаас зохион байгуулж буй “Утаагүй автомашин” аяны хүрээнд тус үйлдвэрийн газар Тээврийн цагдаагийн алба, Нийтийн тээврийн газар, Нийслэлийн замын цагдаагийн газартай хамтран Нийслэлийн нутаг дэвсгэрт зам, замын байгууламжийн ашиглалт, Автотээврийн хэрэгслийн стандартын үзүүлэлт, шаардлагад хяналт тавих хамтарсан шалгалт”-ыг эхлүүлэн ажиллаж, хяналт шалгалтын хүрээнд 860 тээврийн хэрэгслийг шалгаж, 437 тээврийн хэрэгсэлд зөрчил илрүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Автотээврийн үндэсний төв ТӨҮГ тайлант онд суурин болон явуулын 51 төвөөр дамжуулан 662,750 тээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэг хийж, 8691 хүнд мэргэшсэн жолоочийн үнэмлэх олгож, 49 чиглэлд 685 тээврийн хэрэгсэл, 1660 мэргэшсэн жолоочтойгоор 1.4 сая зорчигч урсгалаар хот хоорондын тээвэр хийж, 850 тээврийн хэрэгсэлд Жуулчин таних тэмдгийг олгож, улс хооронд 850,154 зорчигч тээвэрлэж, 7

аймгийн 41 чиглэлд 31 аж ахуйн нэгж байгууллагын дунд оврын 64, суудлын 277 тээврийн хэрэгслээр аймаг хооронд 866 рейсээр 5,433 зорчигч, сум хооронд 1283 рейсээр 169,642 зорчигч тээвэрлэж, 116,000 тээврийн хэрэгслийг шинээр, 636,000 тээврийн хэрэгслийн шилжилт хөдөлгөөнийг бүртгэж, улс, хот хоорондын 76,715 удаагийн тээвэрлэлтийг хянаж, шуурхай зохицуулалтаар хангаж, 8 төв салбарын төвүүдээр дамжуулан илгээмжийн ачааг хүлээн авах, бүртгэлжүүлэх, түр хадгалах үйлчилгээг үзүүлж, 8 боомтын чиглэлд 679 аж ахуйн нэгж байгууллагын 32,892 тээврийн хэрэгсэл, 32,594 мэргэшсэн жолоочтойгоор улс хоорондын ачаа тээвэрлэлтийг гүйцэтгэж, хил нэвтрүүлэлтийн А, В, С, D, E, F зөвшөөрлийн бичгийг олгож, ажилласан байна.

Тайлант онд Засгийн газрын 365 дугаар тогтоолын 5 дугаар зүйлд заасан хил нэвтрэх С зөвшөөрлийн бичгийг олгох эрхийг уурхай эзэмшигч байгууллагуудад олгож, ажилласан байна.

Бусад асуудлын хэсэг

Автотээврийн үндэсний төв ТӨҮГ 2023 онд 12 зорилт, 24 чиглэлийн хүрээнд нийт 95 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 72 арга хэмжээ бүрэн хэрэгжиж, 22 арга хэмжээ хэрэгжих шатанд, 1 арга хэмжээний хугацаа болоогүй, биелэлт 92.9 хувьтай гэж үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт нь бусад мэдээллийг хамраагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдөр

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны	2023 оны
		12-р сарын 31	12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ	16,735,432,814.79	26,676,245,304.00
1.1	Эргэлтийн хөрөнгө	16,735,432,814.79	26,676,245,304.00
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	13,835,989,075.01	24,176,097,182.24
1.1.2	Дансны авлага	6,718,949.60	140,852,998.61
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	409,140,439.56	784,047.00
1.1.4	Бусад авлага	134,142,547.75	39,723,837.59
1.1.6	Бараа материал	2,196,802,718.28	2,200,471,236.63
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	152,639,084.59	118,316,001.91
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	16,735,432,814.79	26,676,245,303.98
1.2	Эргэлтийн бус хөрөнгө	912,455,23.70	38,423,980,829.30
1.2.1	Үндсэн хөрөнгө	31,624,461,589.76	30,420,824,265.99
1.2.2	Биет бус хөрөнгө	6,689,381,329.83	7,951,305,647.11
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	184,291,285.15	51,850,916.20
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	38,498,134,204.74	38,423,980,829.30
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	55,233,567,019.53	65,100,226,133.28
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	199,048,460.25	2,138,280,951.84
2.1.1.3	Татварын өр	6,855,600.00	311,518,093.01
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	450,614,862.19	262,913,795.29
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	51,119,000.00	51,119,000.00
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	707,637,922.44	2,763,831,840.14
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл	5,500,349,778.50	4,941,250,460.28
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	112,481,786.43	-
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	5,612,831,564.95	4,941,250,460.28
2.2	Өр төлбөрийн нийт дүн	6,320,469,487.39	7,705,082,300.42
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч:-төрийн	241,840,000.00	241,840,000.00
2.3.2	хувийн		
2.3.3	хувьцаат		
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	3,159,212,904.41	3,149,852,787.34
2.3.4	Эздийн өмчийн бусад хэсэг	20,494,083,418.75	19,295,044,750.84
2.3.5	Хуримтлагдсан ашиг	25,017,961,208.98	34,708,406,294.68
2.3.6	Эздийн өмчийн дүн	48,913,097,532.14	57,395,143,832.86
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	55,233,567,019.53	65,100,226,133.28

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдөр

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны	2023 оны
		12-р сарын 31	12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	26,051,390,343.43	31,177,459,392.71
2	Борлуулалтын өртөг	21,683,656,033.06	27,712,051,664.40
3	Нийт ашиг(алдагдал)	4,367,734,310.37	3,465,407,728.31
4	Түрээсийн орлого	154,086,815.47	197,829,155.83
5	Хүүгийн орлого	246,629,383.95	921,271,902.84
6	Зорчигч тээврийн орлого	4,757,736,520.69	7,401,942,034.56
8	Бусад орлого	141,515,929.61	1,201,860,980.95
8.1	Орлогын дүн	5,299,968,649.72	9,722,904,074.18
9	Борлуулалт, маркетингийн зардал	35,848,476.50	-
10	Ерөнхий ба удирдлагын зардал	947,429,228.32	2,091,892,779.45
12	Бусад зардал	47,727,346.46	1,266,095.24
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-737,165,140.60	-
17	Бусад ашиг (алдагдал)	-60,115,788.49	-
18	Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)	7,839,416,979.72	11,095,152,927.80
19	Орлогын татварын зардал	998,196,898.94	1,643,476,256.23
20	Татварын дараах ашиг (алдагдал)	6,841,220,080.78	9,451,676,671.57
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	6,841,220,080.78	9,451,676,671.57
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
24	Орлогын нийт дүн	6,841,220,080.78	9,451,676,671.57

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдөр

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	241,840,000.00	3,159,212,904.41	20,286,497,000.00	20,756,581,097.45	44,444,131,000.00
2	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				6,841,220,080.78	6,841,220,080.78
3	Өмчид гарсан өөрчлөлт			207,586,400.00		207,586,400.00
4	Зарласан ногдол ашиг				-2,579,839,969.25	-2,579,839,969.25
5	2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	241,840,000.00	3,159,212,904.41	20,494,083,400.00	25,017,961,208.98	48,913,097,500
6	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				9,451,676,671.57	9,451,676,671.57
7	Өмчид гарсан өөрчлөлт			-1,199,038,649.16	4,323,606.30	-1,194,715,042.86
8	Зарласан ногдол ашиг				-684,112,010.00	-684,112,010.00
9	Дахин үнэлгээний нэмэгдлийн хрэгжсэн дүн		-9,360,117.07		918,556,817.83	909,196,700.76
10	2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	241,840,000.00 0	3,149,852,787.34	19,295,044,750.84	34,708,406,294.68	57,395,143,832.86

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдөр

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	33,765,580,741.34	43,242,219,397.10
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	33,639,467,777.50	43,200,141,240.00
	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		-
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		42,078,157.10
	Буцаан авсан албан татвар		-
	Татаас, санхүүжилтийн орлого		-
	Бусад мөнгөн орлого	72,112,963.84	
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	25,74,574,426.85	29,836,625,606.59
	Ажиллагчдад төлсөн	13,079,436,018.35	17,046,941,165.58
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	1,700,861,630.60	2,264,063,654.70
	Бараа материал худалдан авахад төлсөн	214,025,460.40	559,999,036.00
	Ашиглалтын зардалд төлсөн	1,726,144,442.31	2,662,102,169.05
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	592,894,806.50	530,872,095.09
	Хүүгийн төлбөрт төлсөн	54,621,988.47	112,923,812.94
	Татварын байгууллагад төлсөн	4,608,274,235.53	3,327,808,758.40
	Даатгалын төлбөрт төлсөн	65,452,598.34	60,846,713.00
	Бусад мөнгөн зарлага	3,032,863,246.35	3,271,068,201.83
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	8,691,006,314.49	13,405,593,790.51
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	246,629,383.95	921,271,902.84
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
	Биет бус хөрөнгө борлуулсны орлого		
	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого		
	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого		
	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		
	Хүлээн авсан хүүгийн орлого	246,629,383.95	921,271,902.84
	Хүлээн авсан ногдол ашиг		
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	1,893,932,516.50	5,757,077,297.00
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	1,865,042,516.50	2,056,110,897.00
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	28,890,000.00	700,966,400.00
	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		
	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-1,647,303,132.55	-1,835,805,394.16
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)		
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	3,088,116,524.36	1,229,680,289.12
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	508,276,524.36	545,558,279.12
	Төлсөн ногдол ашиг	2,579,840,000.00	684,122,010.00
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-3,088,166,524.36	-1,229,680,289.12
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	3,955,586,657.58	10,340,108,107.23
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	9,880,402,417.43	13,835,989,075.01
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	13,835,989,075.01	24,176,097,182.24

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдөр

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	2022 оны гүйцэтгэл	2023 оны		Зөрүү	Хувь
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	2	3	4	5	6	7
1	Техникийн хяналтын үзлэгийн орлого	13,074,904,100.0	13,680,000,000.0	14,571,278,833.3	891,278,833.3	106.6
2	Тээвэр зохицуулалтын орлого	8,851,557,521.0	8,554,000,000.0	13,837,700,541.8	5,283,700,541.8	161.8
3	Хөдөлгөөний хяналт, удирдлагын орлого	1,639,000,300.0	1,560,000,000.0	1,946,790,066.6	386,790,066.6	124.8
4	Бүртгэлийн үйлчилгээний орлого	6,770,232,400.0	5,500,000,000.0	8,430,738,148.07	2,930,738,148.1	153.3
5	Үйл ажиллагааны бусад орлого	1,015,664,672.0	360,000,000.0	2,113,855,877.1	1,753,855,877.1	587.2
Нийт орлогын дүн		31,351,358,993.0	29,654,000,000.0	40,900,363,466.9	11,246,363,466.9	137.9
1	Цалин хөлс	11,851,212,412.0	14,506,772,900.0	16,016,337,355.26	1,509,564,455.3	110.4
2	Цалингийн нэмэгдэл, урамшуулал	1,223,438,108.0	1,747,066,900.0	1,392,616,399.75	(354,450,500.3)	79.7
3	Нийгмийн даатгалын шимтгэл	1,702,619,345.0	2,288,263,000.0	2,279,128,600.0	(9,134,400.0)	99.6
4	Албан татвар хураамж /Машины татвар бусад/	159,291,900.0	180,000,000.0	162,060,389.2	(17,939,610.8)	90.0
5	Бичиг хэргийн зардал	188,534,910.0	190,000,000.0	151,942,771.13	(38,057,228.9)	80.0
6	Ашиглалтын зардал	831,033,401.0	1,047,758,400.0	1,151,862,377.02	104,103,977.0	109.9
7	Хангамжийн материалын зардал	138,370,262.0	134,000,000.0	141,806,748.1	7,806,748.1	105.8
8	Бага үнэтэй түргэн элэгдэх зүйлсийн зардал	253,542,011.0	250,000,000.0	364,507,149.9	114,507,149.9	145.8
9	Сургалтын зардал	85,671,708.0	80,000,000.0	92,145,936.4	12,145,936.4	115.2
10	Түрээсийн зардал /байр, тоног төхөөрөмж/	764,112,600.0	1,000,836,100.0	1,566,966,606.6	566,130,506.6	156.6
11	Тогтмол үйлчилгээ, засварын зардал	138,742,900.0	160,000,000.0	190,296,935.1	30,296,935.1	118.9
12	Шатахууны зардал	264,819,200.0	300,000,000.0	293,657,849.3	(6,342,150.7)	97.9
13	Даатгалын зардал	70,893,600.0	58,000,000.0	65,273,714.8	7,273,714.8	112.5
14	Утас, интернэтийн зардал	207,450,100.0	220,000,000.0	271,495,100.0	51,495,100.0	123.4
15	Томилолтын зардал /унаа, буудал, хоол, /дотоод, гадаад/	285,028,785.0	410,000,000.0	466,872,451.4	56,872,451.4	113.9
16	Хэвлэлийн зардал	10,242,600.0	10,000,000.0	19,658,573.0	9,658,573.0	196.6
17	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардал	199,197,000.0	120,000,000.0	117,775,842.5	(2,224,157.5)	98.2
18	Төлбөр хураамж болон Банкны үйлчилгээний зардал бусад зардал	259,098,200.0	184,800,000.0	344,601,769.5	159,801,769.5	186.5
19	Цэвэрлэгээний материалын зардал	25,300,871.0	25,000,000.0	10,450,000.0	(14,550,000.0)	41.8
20	Зар сурталчилгааны зардал	95,004,713.0	100,000,000.0	165,876,500.0	65,876,500.0	165.9

21	Бизнес уулзалт, арга хэмжээний зардал	61,766,800.0	140,000,000.0	183,787,289.0	43,787,289.0	131.3
22	Аудитын зэрэглэл тогтоох үйлчилгээний хөлс	8,000,000.0	9,000,000.0	18,000,000.0	9,000,000.0	200.0
23	Өвөлжилтийн бэлтгэл хангах зардал	64,825,000.0	100,000,000.0	91,842,759.3	(8,157,240.7)	91.8
24	Хөдөлмөр хамгааллын зардал	317,158,000.0	330,300,000.0	332,433,987.8	2,133,987.8	100.7
25	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал	188,379,000.0	310,000,000.0	460,355,899.3	150,355,899.3	148.5
26	Сэлбэг хэрэгслийн зардал	212,006,213.0	216,378,500.0	233,994,545.2	17,616,045.2	108.1
27	Шагнал урамшуулал	4,814,500.0	10,000,000.0	9,919,545.4	(80,454.6)	99.2
28	Ахмадын жилийн зардал	90,873,322.0	110,000,000.0	110,901,484.8	901,484.8	100.8
29	Хог хаягдал устгах	10,396,552.0	20,000,000.0	14,625,699.9	(5,374,300.1)	73.1
30	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмж	129,898,700.0	130,000,000.0	115,166,800.0	(14,833,200.0)	88.6
31	Зээлийн хүүгийн зардал	54,622,000.0	55,000,000.0	54,446,419.6	(553,580.4)	99.0
32	Ажилчдын нийгмийн асуудал шийдвэрлэх зардал	179,500,000.0	200,000,000.0	200,000,000.0	-	100.0
33	Бусад /валютын ханшийн өөрч.бод.бус алдагдал/	737,813,800.0			-	
34	Элэгдлийн зардал	2,698,283,500.2	2,754,727,400.0	2,714,403,110.4	(40,324,289.6)	98.5
Нийт зардлын дүн		23,511,942,013.2	27,397,903,200.0	29,805,210,609.6	2,407,307,409.6	108.8
1	Татварын өмнөх ашиг/алдагдал	7,839,416,979.8	2,256,096,800.0	11,095,152,927.8	8,839,056,127.8	491.8
2	Орлогын албан татвар	998,196,898.9	225,609,700.0	1,643,476,256.2	1,417,866,556.2	728.5
3	Цэвэр ашиг/алдагдал	6,841,220,080.9	2,030,487,100.0	9,451,676,671.6	7,421,189,571.6	465.5
4	Ногдол ашгийн өглөг	3,420,610,040.4	2,213,817,500.0	4,703,208,600.0	2,489,391,100.0	212.5
6	Төсөвт	7,929,663,500.0	7,582,232,800.0	8,423,764,700.0	841,531,900.0	111.1
7	Борлуулалтын 1 төгрөгт ногдох	0.75	0.92	0.73	(0.2)	79.4
5	Хөрөнгө оруулалт	2,491,693,000.0	3,318,566,400.0	2,096,844,701.2	(1,221,721,698.8)	63.2
8	Нийт авлага	550,001,900.0	130,000,000.0	299,676,885.1	169,676,885.1	230.5
9	Нийт өр төлбөр	6,320,469,500.0	4,927,300,700.0	7,705,082,300.4	2,777,781,600.4	156.4

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Автотээврийн үндэсний төв ТӨҮГ нь авто тээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэг хийх, улс, хот хооронд, орон нутгийн нийтийн зорчигч болон ачаа тээвэр, шуудан, жуулчин тээвэрлэлтийн үйлчилгээг улсын хэмжээнд зохицуулах, зохион байгуулах, автотээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, мэргэшсэн жолоочийн шалгалт авах, үнэмлэх олгох, авто үйлчилгээний байгууллагад ангилал тогтоох, автотээврийн салбарын бүтээгдэхүүн үйлчилгээнд тохирлын үнэлгээ хийж, баталгаажуулалт олгох үйл ажиллагаа явуулж байна.

Автотээврийн үндэсний төв ТӨҮГ-ын дүрэмд үйл ажиллагааны чиглэл, чиг үүргийг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

- Тээврийн ухаалаг системд суурилсан, хямд, хүртээмжтэй, тээврийн бусад төрөлтэй уялдсан тээврийн үйлчилгээг тогтвортой үзүүлж, нэгдсэн удирдлага зохицуулалтаар хангана.
- Тээврийн хэрэгслийн тээвэрлэлтийн болон техник ашиглалтын шаардлагыг хангасан байдалд тавих хяналтыг дэлхий нийтээр мөрдөж байгаа стандарт, техникийн зохицуулалт, дэвшилтэт технологид нийцүүлж зам тээврийн осол, түүнээс учирч буй хохирлыг бууруулна.
- Хамтын ажиллагааг өргөжүүлж, судалгаа шинжилгээнд үндэслэсэн, эдийн засаг, нийгмийн эрэлтэд нийцсэн, чанартай, шуурхай, аюулгүй, мэргэжлийн өндөр түвшний үйлчилгээг үзүүлж тээврийн дэд бүтцийг хөгжүүлнэ.
- Мэргэжил, ур чадвар, зөв менежмент хосолсон өрсөлдөх чадвар бүхий хүний нөөцийг бүрдүүлнэ.

Тус үйлдвэрийн газар нь тайлант онд "Автотээврийн талаар төрөөс баримтлах бодлого, зорилтын хүрээнд хэрэглэгчийн эрэлт, хэрэгцээнд нийцсэн, эдийн засгийн үр ашигтай, аюулгүй, ая тухтай тээврийн цогц үйлчилгээг үзүүлэхэд оршино" гэсэн үндсэн зорилтыг дэвшүүлэн ажилласан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Засгийн газрын 2009 оны 07 дугаар сарын 14-ний өдрийн 213 дугаар тогтоолоор Тээврийн хэрэгслийн оношилгоо УТҮГ-ыг байгуулж, Засгийн газрын 2013 оны 10 дугаар сарны 05-ны өдрийн 336 дугаар тогтоолоор Автотээврийн үндэсний төв ТӨҮГ болгон өөрчилсөн байна.

Автотээврийн үндэсний төв ТӨҮГ-ын захирлын 2022 оны А/217 дугаар тушаалаар Захирлын зөвлөлийг нийт 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж, ажиллах журмыг шинэчлэн баталсан байна.

Тайлант хугацаанд компанийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг дараах хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орсон;
- Засгийн газрын 2023 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн 100 дугаар тушаалаар "Төрийн үйлчилгээний асуудал хариуцсан төрийн захиргааны журам", "Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын хүн, хуулийн этгээдэд үзүүлэх үйлчилгээний жагсаалт, "Төрийн үйлчилгээний нэгдсэн системээр дамжуулан мэдээлэл харилцагчаас олгох лавлагаа, тодорхойлолт"-ыг тус тус баталсан;

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 510 дугаар тогтоолоор Автотээврийн үндэсний төв ТӨҮГ-ын зохион байгуулалтын бүтцийг дараах байдлаар шинэчлэн баталж, орон тооны дээд хязгаарыг 775 ажилтан, албан хаагчтай байхаар тогтоосон байна. Үүнд:

- Захирал 1,
- 1 алба,
- 8 хэлтэс,
- 4 тасаг,

- Улаанбаатар хот дахь Судалгаа, хөгжил, чанарын удирдлагын 1 төв,
- Зорчигч тээврийн 2 төв,
- Техникийн хяналтын үзлэгийн 3 төв,
- Аймгийн автотээврийн 21 төв,
- Замын-Үүд, Цогтцэций салбартай.

Тус үйлдвэрийн газар 2023 оны жилийн эцсийн байдлаар 1 алба, 8 хэлтэс, 4 тасаг, 1 төвд 281 орон тоо батлагдсанаас 257 ажилтан, албан хаагч, Улаанбаатар хот дахь Судалгаа, хөгжил, чанарын удирдлагын төв, Зорчигч тээврийн 2 төв, Техникийн хяналтын үзлэгийн 3 төвд 174 орон тоо батлагдсанаас 168 ажилтан, албан хаагч, аймгийн автотээврийн 21 төв, Замын-Үүд, Цогтцэций салбарт нийт 319 орон тоо батлагдсанаас 313 ажилтан, албан хаагч, нийт 738 ажилтан, албан хаагч ажиллаж байна.

Газрын захирлын 2023 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн А/80, А/81 дүгээр тушаалаар тус үйлдвэрийн газрын бүтэц, нэгжийн ажил албан тушаалын жагсаалтыг баталсан байна.

Хяналт, шинжилгээ, дотоод аудитын албаны 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 бүлгийн хүрээнд 30 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 26 ажлыг бүрэн хэрэгжүүлж, 4 ажил дуусаагүй, төлөвлөгөөний биелэлт 86.6 хувийн биелэлттэй гэж дүгнэгдсэн байна.

Автотээврийн үндэсний төв ТӨҮГ-ын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Автотээврийн үндэсний төв ТӨҮГ-ын 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Газрын захирлын 2023 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн А/107 дугаар тушаалаар шинэчлэн баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандаа мөрдөн ажилладаг.

Тус үйлдвэрийн газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

Автотээврийн үндэсний төв ТӨҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан “Аж ахуйн нэгжид мөрдөх ”Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн гол бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 9,866,7 сая төгрөгөөр буюу 15.2 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	13,835,989.1	24,176,097.2	10,340,108.1
Авлага	550,002.0	181,360.9	(368,641.1)
Бараа материал	2,196,802.7	2,200,471.2	3,668.5
Урьдчилж төлсөн зардал, тооцоо	152,639.1	118,316.0	(34,323.1)
Үндсэн хөрөнгө	31,624,461.6	30,420,824.2	(1,203,637.4)
Биет бус хөрөнгө	6,689,381.3	7,951,305.6	1,261,924.3
Хойшлогдсон татварын хөрөнгө	184,291.2	51,851.0	(132,440.2)
Нийт хөрөнгө	55,233,567.0	65,100,226.1	9,866,659.1
Богино хугацаат өр төлбөр	257,023.0	2,500,918.0	2,243,895.0
Урьдчилж орсон орлого	450,614.9	262,913.8	(187,701.1)
Урт хугацаат зээл	5,500,349.8	4,941,250.4	(559,099.4)
Хойшлогдсон татварын өр	112,481.8	-	(112,481.8)
Төрийн өмч	241,840.0	241,840.0	-
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	3,159,212.9	3,149,852.8	(9,360.1)
Эздийн өмчийн бусад хэсэг	20,494,083.4	19,295,044.8	(1,199,038.6)
Хуримтлагдсан ашиг	25,017,961.2	34,708,406.3	9,690,445.1
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	55,233,567.0	65,100,226.1	9,866,659.1

Дээрх хүснэгтээс харахад, өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгө, богино хугацаат өр төлбөр, эздийн өмчийн бусад хэсэг, хуримтлагдсан ашиг дансууд байна. Үүнд:

- Касс дахь бэлэн мөнгөний үлдэгдэл 31.0 сая төгрөг, арилжааны 4 банкны харилцах дансанд нийт 24,145.1 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байна. Үүнээс 3 банкны 4 дансанд 4.6 сая төгрөгийн хугацаатай хадгаламж байршуулсан;
- Авлагын дансны үлдэгдэл 181.4 сая төгрөг болж, тайлант онд GPS буюу хөдөлгөөний хяналтын, техник хяналтын үзлэгийн, татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн, бэлтгэн нийлүүлэгч худалдан авагч нараас авах авлагыг барагдуулснаас 368.6 сая төгрөгөөр буурсан;
- Бараа материал дансны үлдэгдэл 2,200.4 сая төгрөг болж, тайлант онд худалдан авсан 2,882.7 сая төгрөгөөр нэмэгдэж, үйл ажиллагаанд зарцуулсан 2,817.3 сая төгрөг, Газрын захирлын 2023 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн А/147 дугаар тушаалаар акталж, данснаас хассан 69.0 сая төгрөгөөр буурсан зэргээс шалтгаалан 3.5 сая төгрөгөөр өссөн;
- Урьдчилж төлсөн зардал, тооцоо дансны үлдэгдэл 118.3 сая төгрөг болж, худалдан авагч, бэлтгэн нийлүүлэгчид төлөх урьдчилгааг гүйцэтгэгч байгууллагад шилжүүлснээр 34.3 сая төгрөгөөр буурсан;
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 30,420.8 сая төгрөг болж, ТӨБЗГ-ын 2023 оны 555 дугаар тогтоол, 2023 оны А-1/207 дугаар албан бичиг, Дархан-Уул аймгийн Засаг даргын 01-А/151 дүгээр захирамжаар тус тус худалдан авсан 1,928.2 сая төгрөг, салбараас салбарт шилжүүлсэн 1,032.2 сая төгрөг, аудитын зөвлөмжийн дагуу залруулсан 27.6 сая төгрөг, барьцаа хөрөнгө бүртгэсэн 1.5 сая төгрөг, данс хооронд шилжүүлсэн 4.8 сая төгрөг, Газрын захирлын 2023 оны А/278 дугаар тушаалаар дахин үнэлсэн 589.2 сая төгрөгөөр тус тус нэмэгдэж, Засгийн газрын 287 дугаар тогтоол, ТӨБЗГ-ын 2023 оны А-1/2590 дугаар албан бичгийн дагуу ЗТХЯ-ны балансад шилжүүлсэн 1,199.0 сая төгрөг, салбараас салбарт шилжүүлсэн 1,032.2 сая төгрөг, данс хооронд шилжүүлсэн 4.8 сая төгрөг, тайлант үеийн элэгдлийн зардлын 2,551.0 сая төгрөгөөр тус тус хасагдсанаас шалтгаалан 1,203.6 сая төгрөгөөр буурсан;
- Биет бус хөрөнгө дансны үлдэгдэл 7,951.3 сая төгрөг болж, Засгийн газрын 2023 оны 94 дүгээр тогтоолын дагуу худалдан авсан 1,101.0 сая төгрөг, Газрын захирлын 2023 оны А/278 дугаар тушаалаар дахин үнэлсэн 324.3 сая төгрөгөөр нэмэгдэж, тайлант үеийн элэгдлийн зардлын 163.4 сая төгрөгөөр буурсан зэргээс шалтгаалан 1,262.0 сая төгрөгөөр өссөн;

- Хойшлогдсон татварын хөрөнгө дансны үлдэгдэл 51.8 сая төгрөг болж, тайлант үеийн түр зөрүүг бүртгэснээр 132.4 сая төгрөгөөр буурсан;
- Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэл 2,501.0 сая төгрөг болж, аж ахуйн нэгжүүдэд шилжүүлэх зорчигч тээврийн онлайн билет, автомашины дугаарын дуудлага худалдаа, МИАТ-т өгөх газрын үлдэгдэл төлбөрийн дүнгээр 2,243.8 сая төгрөгөөр өссөн;
- Урьдчилж орсон орлого дансны үлдэгдэл 262.9 сая төгрөг болж, харилцагч иргэн, аж ахуйн байгууллагуудад үзүүлсэн үйлчилгээг тайлант үеийн орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэснээр 187.7 сая төгрөгөөр буурсан;
- Урт хугацаат зээл дансны үлдэгдэл 4,941.2 төгрөг болж, Тээврийг хөгжүүлэх төслийн хүрээнд авсан зээлийн тайлант үеийн зээл төлөлтийн 559.1 сая төгрөгөөр буурсан;
- Хойшлогдсон татварын өр дансны үлдэгдэл 0 болж, тайлант үеийн түр зөрүүг тооцож бүртгэснээс шалтгаалан 112.4 сая төгрөгөөр буурсан;
- Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл данс 3,149.8 сая төгрөг болж, элэгдлээрээ өртгөө нөхсөн хөрөнгийг дахин үнэлж бүртгэсэнтэй холбоотой 9.4 сая төгрөгөөр буурсан;
- Эздийн өмчийн бусад хэсэг дансны үлдэгдэл 19.2 сая төгрөг болж, Засгийн газрын 2023 оны 287 дугаар тогтоолоор 1,198.8 сая төгрөгийн, ТӨБЗГ-ын А/2590 дугаар албан бичгээр 0.2 сая төгрөгийн, нийт 1,199.0 сая төгрөгийн байгууллагын өөрийн нэр дээр эзэмшиж байсан барилга, үндсэн хөрөнгийг ЗТХЯ-нд балансаас балансад шилжүүлснээр 1,199.0 төгрөгөөр буурсан;
- Хуримтлагдсан ашиг дансны үлдэгдэл 34,708.4 сая төгрөг болж, тайлант үеийн ашгийн 9,690.4 сая төгрөгөөр буурсан.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Автотээврийн үндэсний төв ТӨҮГ техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

ТӨБЗГ-ын 2022 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 555 дугаар тогтоолоор 2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна.

Тайлант оны нийт орлогыг 29,654.0 сая төгрөгөөр, нийт зардлыг 27,397.9 сая төгрөгөөр, 2,030.4 сая төгрөгийн ашигтай ажиллагаар баталсан байна. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 3,318.6 сая төгрөгийг төлөвлөсөн байна.

Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэлийн нэгтгэл хүснэгт


2023 оны 12 дугаар сарын 31-ний өдөр

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	2022 оны гүйцэтгэл	2023 оны		Зөрүү	Хувь
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	2	3	4	5	6	7
1	Нийт орлого	31,351,358,993.0	29,654,000,000.0	40,900,363,466.9	11,246,363,466.9	137.9
2	Нийт зардал	23,511,942,013.2	27,397,903,200.0	29,805,210,609.6	(2,407,307,409.6)	108.7
	а) ББӨ	22,564,512,784.9	26,285,403,200.0	27,712,051,664.4	1,426,648,464.4	105.4
	б) Ерөнхий ба удирдлагын зардал	947,429,228.3	1,112,500,000.0	2,093,158,874.7	-980,658,874.7	188.2
3	Цэвэр ашиг, алдагдал	6,841,220,081.0	2,030,487,100.0	9,451,676,671.57	-7,421,189,571.6	465.4

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин

Гүйцэтгэлээр 40,900.4 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, үйл ажиллагааны зардалд 29,805.2 сая төгрөгийн зарцуулж, 9,451.7 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна.



Нийт орлогын гүйцэтгэл 40,900.4 сая төгрөг болж, төлөвлөснөөс 11,246.4 сая төгрөг буюу 27.4 хувиар давсан нь бүртгэлийн үйлчилгээ, зорчигч тээвэр, хөдөлгөөн удирдлага, техник хяналт, ачаа тээшийн орлогууд болон хадгаламжийн хүү, түрээсийн орлого нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Нийт зардлын гүйцэтгэл 29,805.2 сая төгрөг болж, төлөвлөснөөс 2,407.3 сая төгрөг буюу 8.8 хувиар илүү буюу хэтэрсэн байна. Энэ нь үндсэн цалин нэмэгдсэн, нийгмийн даатгалын шимтгэл, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал, төв албаны байрны түрээсийн зардал, ашиглалтын зардлыг хэтрүүлэн зарцуулсантай холбоотой байна.

Тайлант онд цэвэр ашиг 9,451.7 сая төгрөг болж, төлөвлөснөөс 7,421.3 сая төгрөгөөр давсан нь орлого нэмэгдсэн нь нөлөөлжээ.

Их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөний дагуу 16 нэр төрлийн 20 багц ажилд 3,318.6 сая төгрөг төлөвлөснөөс өөрийн эх үүсвэрээс 3,284.8 сая төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн байна.

Тайлан онд ТӨБЗГ-т 2022 оны 684.2 сая төгрөгийн ногдол ашиг, түрээсийн орлогын 40 хувь буюу 76.9 сая төгрөгийг тус тус төвлөрүүлжээ.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Автотээврийн үндэсний төв ТӨҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн Автотээврийн үндэсний төв ТӨҮГ, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Автотээврийн үндэсний төв ТӨҮГ-ын үйл ажиллагааг сайжруулахаар он дамжсан авлага, өглөгийн үлдэгдлийг барагдуулах шат дараатай арга хэмжээ авч хэрэгжүүлэх, татварыг зөв тооцоолж, тайлагнах, дуудлага худалдаанаас олсон орлогоос тайлант онд багтаан зохих санд төвлөрүүлэх, зорилтот түвшний төлөвлөгөөг оновчтой зөв төлөвлөж үр ашгийг нэмэгдүүлэх, татварын хууль тогтоомжийн хэрэгжилт, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Гэрэлтэх бүртгэл Аудит ХХК-ийн ахлах аудитор Д.Галт-Эрдэнэ, аудитор С.Дашдэндэв, туслах аудитор Э.Алтангэрэл, Ч.Мөнхбаясгалан нар гүйцэтгэж, чанарын хяналтын менежер Д.Батмөнх, захирал А.Сарангэрэл нар анхан шатны чанарын хяналтыг, Санхүү-нийцлийн аудитын газрын аудитор Ж.Мөнхтуул, аудитын менежер Б.Долгорсүрэн, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны чанарын хяналтыг хэрэгжүүлсэн.

Автотээврийн үндэсний төв ТӨҮГ 2023 оны санхүүгийн тайланг Үндэсний аудитын газарт 2024 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 01/160 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны орлогын тайлангийн нийт зардлын дүнгээр сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны орлогын тайлангийн нийт зардлын дүн 24,510.1 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 245.1 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор үйлдвэрийн газар хангамж болон үйл ажиллагаанд тавих хязгаарлалтуудыг мөрдөж, хэмнэлтийн горимыг баримтлан ажилласан бөгөөд зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг хэмнэж ажилласнаар 2,407.3 сая төгрөгийн хэмнэлтийг бий болгосон боловч дараах асуудлууд илэрсэн. Үүнд:

Илрүүлэлт 1. Зорилтот түвшний төлөвлөгөөгөөр томилолтын зардлыг 410.0 сая төгрөгөөр төлөвлөснөөс 466.8 сая төгрөгийн гүйцэтгэлтэй, 56.8 сая төгрөгөөр буюу 14 хувиар төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан нь тайлант онд ЗТХС-ын болон ТӨБЗГ-ын даргын дараах тушаалаар гадаад албан томилолтын зардал гаргахыг даалгасныг үндэслэн нийт 31.8 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулснаас шалтгаалсан байна. Үүнд:

- 2023 оны А/188 дугаар тушаалаар БНХАУ-д болсон албан ажлын айлчлалын хүрээнд ЗТХЯ-ны нэр бүхий 2 албан хаагчид 15.1 сая төгрөг,
- 2023 оны А/180 дугаар тушаалаар Оросын холбооны улсад болсон Улаанбаатар төмөр зам ХНН-тэй холбоотой албан ажлын айлчлалын хүрээнд УИХ дахь намын бүлгийн ажлын хэсгийн 1 ажилтанд 5.9 сая төгрөг,

- ТӨБЗГ-ын даргын А/50 дугаар тушаалаар БНХАУ-д болсон Төрийн өмчийн хяналт, зохицуулах хороотой харилцан ойлголцлын санамж бичиг байгуулж, хамтын ажиллагааг тогтоож, туршлага судлах албан ажлын хүрээнд тус газрын нэр бүхий 1 албан хаагчид 10.8 сая төгрөг.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.9-д "хариуцлагатай байх", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", 15.2.3-т "...тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх" гэж заасантай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлээгүй, баталсан зардлыг зориулалтын дагуу хэмнэлттэй зарцуулаагүй, зориулалтын бус зардлыг гаргасан зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах талаар албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт 2. Байгууллагад бүртгэлтэй 5 суудлын автомашиныг албан томилолт, хяналт шалгалтаар болон байгууллагын үйл ажиллагаанд ашиглан шатахууны зардалд 71.6 сая төгрөг, 7 автомашины грашийн түрээсийн төлбөрт 14.1 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6.3-т "Энэ хуулийн 3.1-д заасан этгээд орон нутагт албан томилолтоор, хуульд заасан эрх бүхий этгээд газар дээрх хяналт шалгалтаар ажиллахад хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, эсхүл төрийн болон орон нутгийн өмчийн автотээврийн байгууллагаар үйлчлүүлэхээс бусад тохиолдолд автомашин ашиглахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлээгүй, баталсан зардлыг зориулалтын дагуу хэмнэлттэй зарцуулаагүй зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах талаар албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт 3. Тайлант онд 11 ширхэг 49.7 сая төгрөгийн компьютер, дагалдах хэрэгслийг цахим дэлгүүрээс худалдан аваагүй байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.9-д "хариуцлагатай байх", 14 дүгээр зүйлийн 14.1-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан захиалагч нь тухайн жилд худалдан авах 10 сая төгрөгөөс дээш өртөг бүхий бараа, үйлчилгээний жагсаалтыг цахим дэлгүүрт байршуулах хүсэлтийг өмнөх онд худалдан авсан тоо хэмжээ, нэгж үнийн хамт төрийн худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ", 14.4-т "Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно" гэж заасантай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлээгүй, барааг цахим дэлгүүрээс худалдан аваагүй зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах талаар албан шаардлага хүргүүлэв.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 4153 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Автотээврийн үндэсний төв ТӨҮГ тайлант онд Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст нийт 141,052.1 сая төгрөгийн 4153 мэдээллийг ил тод байршуулахаас цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 2,142.4 сая төгрөгийн орлогын 91 гүйлгээ, 6,948.3 сая төгрөгийн зарлагын 218 гүйлгээ, нийт 9,090.8 сая төгрөгийн 190 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.4-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр", гэж тус тус заасныг зөрчсөн, "нийцсэн бөгөөд зохистой байх" санхүүгийн тайлангийн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим хуудсанд байршуулах мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах талаар албан шаардлага өгөв.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн хүрээнд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй, бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар шалгагдагч байгууллагын 2023 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланг хамруулж, авлага, өглөг, бараа материал, үндсэн хөрөнгө, орлого, зардлын данснуудад горим, сорил хэрэгжүүлж, илрүүлэлтийг шалгагдагч байгууллагад асуудлын бүртгэлээр танилцуулж, баталгаажуулсан.

Завсрын аудитаар илэрсэн авлага, өр төлбөрийг сөрөг дүнгээр тайлагнасан, хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг буруу бүртгэсэн, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн хөрөнгийг дахин үнэлж, бүртгэлд тусгаагүй, ажилтны цалингаас суутгасан татварыг буруу тооцоолж, цалинг илүү олгосон зэрэг нийт 1,804,7 сая төгрөгийн алдааг залруулсан, шүүхийн шийдвэрээр эргүүлэн тогтоолгосон ажилтны ажилгүй байсан хугацааны цалин, хөлстэй тэнцэх олговрыг байгууллагын харилцах данснаас гаргаж, буруу шийдвэр гаргасан албан тушаалтнаас авлага үүсгэж, нөхөн төлүүлээгүй 19.0 сая төгрөгийн зөрчлийг арилгаж, төлбөрийг бүрэн барагдуулсан.

Он дамжсан, хугацаа хэтэрсэн авлага, өр төлбөрийг шийдвэрлэх, шат дараатай арга хэмжээ авах 2 зөрчил хэрэгжээгүй тул тайлант оны буруу илэрхийлэлд оруулан тооцов.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх онд төв, алба болон салбаруудад хийсэн аудитаар 5 салбарын 493.8 сая төгрөгийн 10 алдааг залруулж, нийт 15 салбарт илэрсэн 1,191.7 сая төгрөгийн санхүүгийн аудитын зөрчлөөс 13.3 сая төгрөгийн 4 актыг барагдуулж, 5 салбарын 570.9 сая төгрөгийн 14 албан шаардлагыг 99.8 хувьтай биелүүлж, 15 салбарын 606.4 сая төгрөгийн 33 зөвлөмжийг, 5 салбарын 809.7 сая төгрөгийн нийцлийн аудиттай холбоотой өгсөн 3 зөвлөмжийг тус тус хэрэгжүүлэн ажилласан байна.

Хүснэгт 4. Нийт төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт



/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	4	13,344.1	4	13,344.1	100.0
Албан шаардлага	15	571,906.3	14	570,964.9	99.8
Зөвлөмж	36	1,416,139.8	36	1,416,139.8	100.0
Нийт дүн	55	2,001,390.2	54	2,000,448.8	99.9

НАӨТ-ын тайланд тусгасан чөлөөлөгдөх борлуулалт, орлого үр дүнгийн тайланд зөрүүтэй тайлагнасан зөрчлийг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар дуудлага худалдааны орлогыг зохих санд хугацаанд нь төвлөрүүлсэн эсэх, НӨАТ-ын болон Орлого үр дүнгийн тайланд чөлөөлөгдөх борлуулалтын орлогыг зөрүүтэй тайлагнасан эсэхийг авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой төв албаны 35.7 сая төгрөгийн 1 алдаа, салбаруудын 0.4 сая төгрөгийн 2 алдаа¹, илэрснийг аудитын явцад залруулга хийлгэж, баталгаажуулав. Үүнд:

- Төв алба: Худалдан авсан 3 ширхэг автотээврийн хэрэгслийн НӨАТ-ыг 35.7 сая төгрөгөөр нэмэгдүүлэн залруулсныг капиталжуулснаар бүртгэж тайлагнасан.

Аудитаар төв алба, салбаруудад нийт 209.1 сая төгрөгийн 24 зөрчил² илэрснээс, 168.6 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 6 албан шаардлага хүргүүлж, 40.5 сая төгрөгийн 18 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 209.1 сая төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 36.0 сая төгрөгөөр бага тул Өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

5.1 Албан шаардлага

Илрүүлэлт 1. Татварын авлага, өр төлбөрийн тооцоог хянаж, тайлант үе бүрийн эцэст тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүйгээс тайлант оны эцэст нэмэгдсэн өртгийн албан татварын тайланд чөлөөлөгдөх борлуулалтын орлогыг 8,322.9 сая төгрөгөөр, Орлогын дэлгэрэнгүй тайланд 8,321.9 сая төгрөгөөр тус тус тайлагнаж, 0.9 сая төгрөгөөр илүү тайлагнасан байна.

Энэ нь Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5-д "Дараах үйлчилгээг албан татвараас чөлөөлнө", Авто тээврийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.11-д "Нийтийн тээврийн үйлчилгээ", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах" гэж заасантай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Татварын авлага, өр төлбөрийн тооцоог хянаж, тайлант үе бүрийн эцэст тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, нэмэгдсэн өртгийн албан татварын тайлан болон Орлого үр дүнгийн тайланд чөлөөлөгдөх борлуулалтын орлогыг зөрүүтэй тайлагнасан зөрчлийг арилгаж, зөрчлийг давтан гаргахгүй, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах талаар албан шаардлага өгөв.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Дуудлага худалдааны орлогыг төвлөрүүлэхтэй холбоотой

Илрүүлэлт 1. Тээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаарын дуудлага худалдаанаас 6,604.0 сая төгрөгийн орлого олж, Хүүхдийн төлөө санд 5,943.6 сая төгрөгийг төвлөрүүлэхээс 4,971.8 сая төгрөгийг төвлөрүүлж, 971.8 сая төгрөгийг тайлант онд багтаан төвлөрүүлээгүй, 2024 оны 01 дүгээр сарын 31-ны өдөр төвлөрүүлсэн байна.

Энэ нь Зам тээврийн хөгжлийн сайдын 2022 он А/27 дугаар тушаалаар баталсан "Тээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаарын дуудлага худалдааг зохион байгуулах журам"-ын 2 дугаар зүйлийн 2.10-т "Тээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаарын дуудлага худалдаанаас төвлөрүүлсэн орлогоос дуудлага худалдааны үйл ажиллагааны зардалд 10 хувийг суутган тооцож, холбогдох хууль тогтоомжийн дагуу тусгай санд төвлөрүүлнэ", Авто тээврийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 171.4-т "Энэ хуулийн 171.3-т заасан орлогыг Хүүхдийн төлөө санд төвлөрүүлнэ", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах" гэж заасантай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Тусгай санд төвлөрүүлэх орлогын тооцоог тогтмол хянаж, тайланд онд багтаан төвлөрүүлж ажиллахыг зөвлөж байна.

2. Зорилтот түвшнийг оновчтой зөв төлөвлөж, үр ашгийг нэмэгдүүлэх талаар

Илрүүлэлт 2. Зорилтот түвшний төлөвлөгөөнд баталсан түрээсийн зардлыг тус газрын үндсэн байрыг оны дундуур төрийн мэдэлд шилжүүлэн чөлөөлж, байр суллах мэдэгдэл 2023 оны 09 дүгээр сард гарснаас хойших хугацааны түрээсийн төлөвлөгөөг тооцоо судалгаанд үндэслэн тооцоогүйгээс шалтгаалан 566.1 сая төгрөгөөр буюу 57 хувиар хэтрүүлэн зарцуулсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдлага жил бүрийн 3 дугаар сарын 01-ний дотор тухайн хуулийн этгээдийн зорилт, түүнийг хэрэгжүүлэх талаарх санал /цаашид "зорилтын санал" гэх/-ын төслийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ", 21.2-т "санхүүгийн төлөв, түүний дотор төлөвлөж байгаа ашиг" гэж заасантай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Зорилтот түвшний үр ашгийн зохистой харьцааг хянаж, зардлыг оновчтой зөв төлөвлөж, компанийн үр ашгийг нэмэгдүүлж ажиллахыг зөвлөж байна.

3. Он дамжсан, хугацаа хэтэрсэн авлагыг барагдуулах, шийдвэрлэх талаар

Илрүүлэлт 3. Авлагын дансны эцсийн үлдэгдэлд 2016 онд үүссэн 2 хувь хүнээс авах 7 жилийн насжилттай 15,432,570.0 төгрөгийн хугацаа хэтэрсэн, он дамжсан авлагатай байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Он дамжсан, хугацаа хэтэрсэн авлагыг барагдуулах шат дараатай үр дүнтэй арга хэмжээ авч, хэрэгжүүлэхийг зөвлөж байна.

4. Он дамжсан, хугацаа хэтэрсэн өглөгийг барагдуулах, шийдвэрлэх талаар

Илрүүлэлт 4. Өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэлд 1 аж ахуйн нэгж, байгууллагад өгөх 7 жилийн насжилттай 1.2 сая төгрөгийн өр төлбөр бүртгэлтэй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Он дамжсан хугацаа хэтэрсэн өр төлбөрийн барагдуулах шат дараатай үр дүнтэй арга хэмжээ авч, хэрэгжүүлэхийг зөвлөж байна.

Харьяа салбаруудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 24.7 сая төгрөгийн 18 алдаа зөрчил илэрснээс 0.4 сая төгрөгийн 2 алдааг залруулж, 0.05 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 0.4 сая төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлж, 23.8 сая төгрөгийн 14 зөвлөмж өгсөн байна.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Запруулсан		Запруулаагүй		Тоо	Дүн	
							Тоо	Дүн	Тоо	Дүн			
Худалдан авсан 3 ширхэг автотээврийн хэрэгслийн НӨАТ-ыг 35,727.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн зарлуулсныг капиталжуулснаар бүртгэж тайлагнасан.	1	35,727.2	-	-	1	35,727.2	1	35,727.2	-	-	-	-	-
Дүн	1	35,727.2	-	-	1	35,727.2	1	35,727.2	-	-	-	-	-

/мянган төгрөгөөр/

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаарын дуудлага худалдаанаас 6,604,960.0 мянган төгрөгийн орлого олж, Хүүхдийн төлөө санд 5,943,564.0 мянган төгрөгийг төвлөрүүлэхээс 4,971,787.4 мянган төгрөгийг төвлөрүүлж, 971,776.6 мянган төгрөгийг тайлант онд багтаан төвлөрүүлээгүй, 2024 оны 01 дүгээр сарын 31-ны өдөр төвлөрүүлсэн.	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-

/мянган төгрөгөөр/

Зорилтот түвшний төлөвлөгөөнд баталсан түрээсийн зардлыг тус газрын үндсэн байрыг оны дундуур төрийн мэдэлд шилжүүлэн чөлөөлж, байр суллах мэдэгдэл 2023 оны 09 дүгээр сард гарснаас хойших хугацааны түрээсийн төлөвлөгөөг тооцоо судалгаанд үндэслэн тооцоогүйгээс шалтгаалан 566,130.5 мянган төгрөгөөр буюу 57 хувиар хэтрүүлэн зарцуулсан.	1	-	-	-	-	-	-	-	1	-	-	-	-
Татварын авлага, өр төлбөрийн тооцоог хянаж, тайлант үе бүрийн эцэст тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүйгээс тайлант оны эцэст нэмэгдсэн өртгийн албан татварын тайланд чөлөөлөгдөх борлуулалтын орлогыг 8,322,905.0 мянган төгрөгөөр, Орлогын дэлгэрэнгүй тайланд 8,321,963.6 мянган төгрөгөөр тус тус тайлагнаж, 941.4 мянган төгрөгөөр илүү тайлагнасан.	1	941.4	-	-	1	941.4	-	-	-	-	-	-	-
Авлагын дансны эцсийн үлдэгдэлд 2016 онд үүссэн 2 хувь хүнээс авах 7 жилийн насжилттай 15,432.6 мянган төгрөгийн хугацаа хэтэрсэн, он дамжсан авлагатай.	1	15,432.6	-	-	-	-	-	-	1	15,432.6	-	-	-
Өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэлд 1 аж ахуйн нэгж, байгууллагад өгөх 7 жилийн насжилттай 1,170.00 мянган төгрөгийн өр төлбөр бүртгэлтэй	1	1,170.0	-	-	-	-	-	-	1	1,170.0	-	-	-
Дүн	5	17,544.0	-	-	1	941.4	-	-	4	16,602.6	-	-	-

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

01 ӨӨРЧЛӨЛТГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс				/мянган төгрөгөөр/	
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Тоо	Зөвлөмж
			Тоо	Дүн	Тоо	Дүн		
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 91, зарлагын 218, нийт 309 гүйлгээний 9,090,766.5 мянган төгрөгийн мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.	1	9,090,766.5	-	-	1	9,090,766.5	-	-
Дүн	1	9,090,766.5	-	-	1	9,090,766.5	-	-
Төрийн хэмнэлтийн тухай хуультай холбоотой зөрчил								
Байгууллагад бүртгэлтэй 5 суудлын автомашиныг албан томилолт, хяналт шалгалтаар болон байгууллагын үйл ажиллагаанд ашиглан шатахууны зардалд 71,595.6 мянган төгрөг, 7 автомашины грашийн түрээсийн төлбөрт 14,090.4 мянган төгрөг, нийт 85,686.0 мянган төгрөгийг арвилан хэмнэлтгүй зарцуулсан байна.	1	85,686.0	-	-	1	85,686.0	-	-
Тайлант онд ЗТХС-ын болон ТӨБЗГ-ын даргын тушаалаар гадаад албан томилолтын зардал гаргахыг даалгасныг үндэслэн нийт 31,846.8 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулж, зорилтот түвшний баталсан төлөвлөгөөг 56,872.4 мянган төгрөгөөр буюу 14 хувиар төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна	1	31,846.8	-	-	1	31,846.8	-	-
Тайлант хугацаанд 11 ширхэг 49,746.4 мянган төгрөгийн компьютер, дагалдах хэрэгслийг цахим дэлгүүрээс худалдан аваагүй байна.	1	49,746.4	-	-	1	49,746.4	-	-
Дүн	3	167,279.2	-	-	3	167,279.2	-	-
Нийт дүн	4	9,258,045.7	-	-	4	9,258,045.7	-	-

Харьяа салбаруудын санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Салбаруудын нэрс	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
		Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Залруулсан		Залруулаагүй		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Орхон аймгийн Автотээврийн үндэсний төв	Автотээврийн үндэсний төвийн даргын 2023.06.09-ны өдрийн Б/253 дугаар тушаалаар даргын үүргийг түр орлон гүйцэтгүүлсний нэмэгдлийг 370,886 төгрөгөөр илүү тооцож олгосон.	1	370.9	-	-	1	370.9	1	370.9	-	-	-	-
	Автотээврийн үндэсний төвийн даргын 2023.03.15-ны өдрийн Б/89 дугаар тушаалаар И.Ловонгончигийн 3-р сарын үндсэн цалинг 20 хувиар бууруулах /1сар/ сахилгын шийтгэл оногдуулсныг 4 болон 5 дугаар сарын цалинг 20 хувиар бууруулан тооцож, илүү суутгасан 1 сарын цалинг буцаан олгохдоо 26,130 төгрөгийг дугуу олгосон.	1	26.1	-	-	1	26.1	1	26.1	-	-	-	-
	Дүн	2	370.0	-	-	2	370.0	2	370.0	-	-	-	-

Харьяа салбаруудын санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Салбарууд	Алдааны товч утга	Үүнээс									
		Нийт зөрчил		Төлбөрийн акт		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн



Архангай аймаг дахь Автотээврийн үндэсний төв	Тээвэр шатахуунд 9,326.5 мянган төгрөгийг зарцуулсныг анхан шатны баримтаар тулган шалгахад шатах тослох материал хэдэн литр шатах тослох материал худалдан авсан нь тодорхойгүй, бөөн дүнгээр орлогод авч, зарлагадсан.	1	9,326.5	-	-	-	-	-	1	9,326.5	-	-	-	-
Булган аймаг дахь Автотээврийн үндэсний төв	Тайлант онд андуурсан, эзэн холбогдогч нь тодорхойгүй техникийн үзлэг болон оношлогооны орлого 1068.2 мянган төгрөгөөр нэмэгдсэн	1	1,068.2	-	-	-	-	-	1	1,068.2	-	-	-	-
Говьсүмбэр аймаг дахь Автотээврийн үндэсний төв	Цалин, ээлжийн амралтыг давхардуулж олгосон	1	55.6	1	55.6	-	-	-	-	-	-	-	-	-
	Малын нэмнээ худалдан авч төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан	1	454.6	-	1	454.6	-	-	1	-	-	-	-	-
Дундговь аймаг дахь Автотээврийн үндэсний төв	Анхан шатны баримтын стандартын дагуу архивлаагүй, анхан шатны баримтын ард өөр баримт хэвлэсэн	1	-	-	-	-	-	-	1	-	-	-	-	-
	Анхан шатны баримтын бүрдэл дутуу баримтаар албан томилолтыг олгосон.	1	-	-	-	-	-	-	1	-	-	-	-	-
Дорнод аймаг дахь Автотээврийн үндэсний төв	Шатахуун зарлагагдахдаа шаардах хуудас хөтөлж ажиллаагүй.	1	-	-	-	-	-	-	1	-	-	-	-	-
Орхон аймаг дахь Автотээврийн үндэсний төв	Анхан шатны баримтын бүрдэлгүй томилолтын зардал олгосон.	1	-	-	-	-	-	-	1	-	-	-	-	-
	Хөрөнгийн үнэлгээг хийгээгүй	1	-	-	-	-	-	-	1	-	-	-	-	-

Сэлэнгэ аймаг дахь Автотээврийн үндэсний төв	Байгууллагад ашиглаж буй програмаас шалтгаалан бараа материалын дэлгэрэнгүй бүртгэлийг НӨАТ хасагдсан дүнгээр тооцож, улмаар бараа материалын тайлан болон дэлгэрэнгүй бүртгэлийн дүн хоорондоо зөрүүтэй тайлагдсан	1	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
	Сонгинохайрхан Техник хяналтын үйлчилгээний төв	Үндсэн хөрөнгийн тооллогыг холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу хийгээгүй, баримтжуулаагүй, баталгаажуулаагүй, тооллогыг чанаргүй гүйцэтгэсэн	1	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Сонгинохайрхан Зорчигч тээврийн төв	Бараа материалын тооллого хийхдээ тооцоо бодоогүй	1	312.0	-	-	-	-	-	-	-	-	312.0	-	-	-	-	-	-	-
	Санхүүгийн тайлангийн толилуулга бичээгүй	1	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
	Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг дугуу тооцож хөрөнгийн үлдэгдлийг буруу тайлагнасан.	1	287.0	-	-	-	-	-	-	-	-	287.0	-	-	-	-	-	-	-
	Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг харилцан адилгүй буюу зөрүүтэй тооцсон, хөрөнгийн дансны ангиллыг буруу бүртгэсэн,НББ-ийн бодлогын өөрчлөлт ба тооцооллын өөрчлөлтийн бүртгэлийг хийгээгүй.	1	12,792.0	-	-	-	-	-	-	-	-	-	12,792.0	-	-	-	-	-	-
Түрээсийн гэрээний нэмэлт өөрчлөлтийг гарын үсэг зурж, тамга тэмдэг дэран баталгаажуулаагүй буюу үндсэн гэрээний холбогдох заалтыг хэрэгжүүлээгүй.		1	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Дүн		16.0	24,295.9	1	55.6	1	454.6	14	23,785.7	-	-	-	-	-	-	-	-	-	-

Харьяа салбаруудын санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Салбарууд	Алдааны товч утга	Нийт зөрчил		Үүнээс				Зөвлөмж	
		Төлбөрийн акт		Албан шаардлага		Тоо	Дүн	Тоо	Дүн
		Тоо	Дүн	Тоо	Дүн				
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
Орхон аймаг дахь Автотээврийн үндэсний төв	Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 7 гүйлгээг мэдээлээгүй, 2 мэдээллийг хугацаа хоцроосон.	1	561,446.2	-	-	-	-	1	561,446.2
Сонинохайрхан Техник хяналт, үйлчилгээний төв	Шилэн дансны мэдээлэлд дараа жилийн төсвийн төслийг хугацаа хоцроон байршуулсан.	1	-	-	-	-	-	1	-
	Дүн	2	561,446.2	-	-	-	-	2	561,446.2



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 дугаар сарын 25 № 741/АО/50092

Улаанбаатар хот

ОМАГ-2024/86/НА-СТА-ТӨА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Автотээврийн үндэсний төв ТӨҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ.

Тайлант онд ЗТХС-ын болон ТӨБЗГ-ын даргын дараах тушаалаар гадаад албан томилолтын зардал гаргахыг даалгасныг үндэслэн нийт 31,846,838.00 төгрөгийг зориулалт бусаар зарцуулж, зорилтот түвшний баталсан төлөвлөгөөг 56,872,400.00 (тавин зургаан сая найман зуун далан хоёр мянга дөрвөн зуун) төгрөгөөр буюу 14 хувиар төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна. Үүнд:

- 2023 оны А/188 дугаар тушаалаар БНХАУ-д болсон албан ажлын айлчлалын хүрээнд ЗТХЯ-ны нэр бүхий 2 албан хаагчид 15,124,040.00 төгрөг;
- 2023 оны А/180 дугаар тушаалаар Оросын холбооны улсад болсон Улаанбаатар төмөр зам ХНН-тэй холбоотой албан ажлын айлчлалын хүрээнд УИХ дахь намын бүлгийн ажлын хэсгийн 1 ажилтанд 5,948,768.00 төгрөг;
- ТӨБЗГ-ын даргын А/50 дугаар тушаалаар БНХАУ-д болсон Төрийн өмчийн хяналт, зохицуулах хороотой харилцан ойлголцлын санамж бичиг байгуулж, хамтын ажиллагааг тогтоож, туршлага судлах албан ажлын хүрээнд тус газрын нэр бүхий 1 албан хаагчид 10,774,030.00 төгрөг.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.9-д "хариуцлагатай байх", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", 15.2.3-т "...тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-д "албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана", 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлээгүй, баталсан зардлыг зориулалтын дагуу хэмнэлттэй зарцуулаагүй, зориулалтын бус зардлыг гаргасан зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 9 дүгээр сарын 02-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Автотээврийн үндэсний төв ТӨҮГ-ын Захирал /Б.Гүрсоронзон/, Ерөнхий нягтлан бодогч /Г.Дуламханд/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨТСӨН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ГЭРЭЛТЭХ БҮРТГЭЛ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ


Ц.НАРАНЧИМЭГ
Б.ДОЛГОРСҮРЭН


А.САРАНГЭРЭЛ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 дугаар сарын 25 № 742/АД/50092

Улаанбаатар хот

СНАГ-2024/86/НА-ЛТА-ТӨА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Автотээврийн үндэсний төв ТӨҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ.

Байгууллагад бүртгэлтэй 5 суудлын автомашиныг албан томилолт, хяналт шалгалтаар болон байгууллагын үйл ажиллагаанд ашиглан шатахууны зардалд 71,595,582.40 төгрөг, 7 автомашины грашийн түрээсийн төлбөрт 14,090,450.00 төгрөг, нийт 85,686,032.40 (наян таван сая зургаан зуун наян зургаан мянга гучин хоёр төгрөг дөчин мөнгө) төгрөгийг арвилан хэмнэлтгүй зарцуулсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6.3-т "Энэ хуулийн 3.1-д заасан этгээд орон нутагт албан томилолтоор, хуульд заасан эрх бүхий этгээд газар дээрх хяналт шалгалтаар ажиллахад хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, эсхүл төрийн болон орон нутгийн өмчийн автотээврийн байгууллагаар үйлчлүүлэхээс бусад тохиолдолд автомашин ашиглахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-д "албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана", 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлээгүй, баталсан зардлыг зориулалтын дагуу арвилан хэмнэлтгүй зарцуулсан зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 9 дүгээр сарын 02-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Автотээврийн үндэсний төв ТӨҮГ-ын Захирал /Б.Гүрсоронзон/, Ерөнхий нягтлан бодогч /Г.Дуламханд/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ГЭРЭЛТЭХ БҮРТГЭЛ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Б.ДОЛГОРСҮРЭН

А.САРАНГЭРЭЛ

0001081011



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 дугаар сарын 25 № 743/А0150092

Улаанбаатар хот

СМАГ-2024/86/НА-СТА-Т.ВА
Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Автотээврийн үндэсний төв ТӨҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ.

Тайлант хугацаанд 11 ширхэг 49,746,400.00 (дөчин есөн сая долоон зуун дөчин зургаан мянга дөрвөн зуун төгрөг) төгрөгийн компьютер, дагалдах хэрэгслийг цахим дэлгүүрээс худалдан аваагүй байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.9-д "хариуцлагатай байх", 14 дүгээр зүйлийн 14.1-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан захиалагч нь тухайн жилд худалдан авах 10 сая төгрөгөөс дээш өртөг бүхий бараа, үйлчилгээний жагсаалтыг цахим дэлгүүрт байршуулах хүсэлтийг өмнөх онд худалдан авсан тоо хэмжээ, нэгж үнийн хамт төрийн худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ", 14.4-т "Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно" гэж заасантай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.9-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлээгүй, худалдан авах ажиллагааг холбогдох хууль журмын дагуу зохион байгуулаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 9 дүгээр сарын 02-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Автотээврийн үндэсний төв ТӨҮГ-ын Захирал /Б.Гүрсоронзон/, Ерөнхий нягтлан бодогч /Г.Дуламханд/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ГЭРЭЛТЭХ БҮРТГЭЛ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Б.ДОЛГОРСҮРЭН
А.САРАНГЭРЭЛ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024

оны 03

дугаар сарын

25

№

744/А0150092

Улаанбаатар хот

УНАГ-2024/86/НА-СТА-ТӨА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Автотээврийн үндэсний төв ТӨҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ.

Татварын авлага, өр төлбөрийн тооцоог хянаж, тайлант үе бүрийн эцэст тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүйгээс тайлант оны эцэст нэмэгдсэн өртгийн албан татварын тайланд чөлөөлөгдөх борлуулалтын орлогыг 8,322,905,018.78 төгрөгөөр, Орлогын дэлгэрэнгүй тайланд 8,321,963,626.78 төгрөгөөр тус тус тайлагнаж, 941,392.00 (есөн зуун дөчин нэгэн сая гурван зуун ерэн хоёр төгрөг) төгрөгөөр илүү тайлагнасан байна.

Энэ нь Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5-д "Дараах үйлчилгээг албан татвараас чөлөөлнө", Авто тээврийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.11-д "Нийтийн тээврийн үйлчилгээ", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Татварын авлага, өр төлбөрийн тооцоог хянаж, тайлант үе бүрийн эцэст тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, нэмэгдсэн өртгийн албан татварын тайлан болон Орлого үр дүнгийн тайланд чөлөөлөгдөх борлуулалтын орлогыг зөрүүтэй тайлагнасан зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 9 дүгээр сарын 02-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Автотээврийн үндэсний төв ТӨҮГ-ын Захирал /Б.Гүрсоронзон/, Ерөнхий нягтлан бодогч /Г.Дуламханд/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ГЭРЭЛТЭХ БҮРТГӨЛ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Б.ДОЛГОРСҮРЭН

А.САРАНГЭРЭЛ

0001081015



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 дугаар сарын 25 № 745/А0150092

Улаанбаатар хот

СНАГ-2024) 86/НА-УТА-ТӨА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Автотээврийн үндэсний төв ТӨҮГ-ын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ.

Тайлант онд Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 91, зарлагын 218, нийт 309 гүйлгээний 9,090,766,528.99 (есөн тэрбум ерэн сая долоон зуун жаран зургаан мянга таван зуун хорин найман төгрөг ерэн есөн мөнгө) төгрөгийн мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.4-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр", гэж тус тус заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

- Шилэн дансны цахим хуудсанд байршуулах мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 9 дүгээр сарын 02-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
- Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Автотээврийн үндэсний төв ТӨҮГ-ын Захирал /Б.Гүрсоронзон/, Ерөнхий нягтлан бодогч /Г.Дуламханд/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ГЭРЭЛТЭХ БҮРТГЭЛ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Б.ДОЛГОРСҮРЭН
А.САРАНГЭРЭЛ

0001081017

